

- доор дурдсан тохиолдлуудад Хөдөлмөрийн товчооны бүртгэлээс хасагдана (хасагдсанаас 6 сарын дараа дахиад бүртгүүлэх өргөдөл өгч болно):
 - **ноцтой шалтгаангүйгээр** ажилд орохоос татгалзсан
 - та Хөдөлмөрийн товчоогоор зуучилсан ажлын харилцааг **ноцтой шалтгаангүйгээр** (ноцтой шалтгааны жишээ нь: эрүүл мэндийн байдал, ойр дотны хүнээ асарч байгаа эсвэл ажил олгогч цалин төлдөггүй) халагдах бичиг өгснөөр юмуу тохиролцоогоор цуцласан
 - ажлын үүргээ бүдүүлгээр зөрчсөн шалтгаанаар ажил олгогч таныг ажлаас халсан

– та **ноцтой шалтгаангүйгээр** нийгмийн үйлчилгээ юмуу нийгмийн тустай хөдөлмөрөөс татгалзсан

Хөдөлмөрийн товчооны ажилтан таныг DONEZ (docházka nezaměstnaných – ажилгүйчүүдийн ирц) гэдэг системд доор дурдсан тохиолдолд бүртгүүлж болно: та хэд хэдэн удаа Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлд бүртгүүлвэл, сүүлийн 6 сарын турш нэг юмуу хэдэн түр хугацааны ажил эрхэлсэн бол, та 26-аас доош насны эсвэл тодорхой мэргэжилтэй байвал

- DONEZ системд бүртгүүлсэн хүн тогтоосон цагт шуудангийн эсвэл дүүргийн Czech POINT гэдэг газарт очих үүрэгтэй. Хөдөлмөрийн товчоо тодорхой өдөр, цаг тогтооно (долоо хоногт 3 удаа очих үүрэгтэй болно, өвчтэй байсан тохиолдолд Хөдөлмөрийн товчоонд эмчийн тодорхойлолт авчрах хэрэгтэй).
- Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлд бүртгүүлснээс 2 сарын дараа Хөдөлмөрийн товчоо долоо хоногт 20 цагийн нийгэмд тустай хөдөлмөрт (ч.х.: **veřejně prospěšné práce**) зуучилж болно. Нийгэмд тустай хөдөлмөр таны мэргэжлээс өөр байж болно. Та ажилласан цагтаа цалин авах боловч ажилгүйдлийн тэтгэмж авахгүй.
- Та Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлд бүртгүүлснээс 1 жилийн дараа Хөдөлмөрийн товчоо танаас нэг долоо хоногт 20 цагийн нийтийн үйлчилгээний ажил (ч.х.: **veřejná služba**) оноож болно (жишээ нь: олон нийтийн газрын цэвэрлэгээ). Нийтийн үйлчилгээний ажил эрхлэх нь ажилгүйдлийн тэтгэмж үргэлжлүүлэн авах нөхцөл бөгөөд энэ ажлын хөлс гэж цалин авахгүй.
- Та ноцтой шалтгаангүйгээр нийтийн үйлчилгээ юмуу нийгэмд тустай хөдөлмөрөөс татгалзвал Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлээс *тохиромжтой ажлын байрнаас татгалзсан* гэсэн үндэслэлтэйгээр хасагдах болно. Хасагдсанаас 6 сарын дараа дахиад бүртгүүлэх өргөдөл өгч болно. Энэ тохиолдолд та онцгой байдлын мөнгөн тусламж авах эрхгүй.
- Хэрэв чухал өөрчлөлт хийвэл Хөдөлмөрийн товчоонд **8 хоногийн дотор** мэдэгдэнэ (өвчин, орон сууцны ба бичиг баримтын өөрчлөлт, банкны дансны өөрчлөлт, нэмэгдэл түр ажил, бригад)!

9

Хөдөлмөрийн товчоонд бүртгүүлсэн үед түр ажил хийж болох тухай

- Ажилгүйдлийн тэтгэмж авах үед ажил хийж болохгүй. Бага цалинтай түр ажил байсан ч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхээ хасуулна.
- Та Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлд бүртгэлтэйгээр, ажилгүйдлийн тэтгэмж авахгүйгээр тодорхой хүлээн зөвшөөрөгдсөн ажил эрхэлж болно. Ийм ажлын сарын цалин 4000 кронаос илүүгүй байна.
- Хөдөлмөрийн товчоонд 8 хоногийн дотор түр ажил эсвэл бригад хийх тухай мэдэгдэнэ, энэ ажил нь хүсэлт гаргагчийн үүрэгд саад хийж болохгүй!
- Хөдөлмөрийн товчоо таныг зүй ёсны бус ажил хийх эсвэл зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү цалин авсан тухай мэдвэл таныг бүртгэлээс хасах буюу та өөрөө хариуцлага хүлээнэ.

10

Та шинэ ажлын байр олсон уу?

- шинэ ажилд орохын өмнө Хөдөлмөрийн товчоонд энэ тухайгаа мэдэгдэнэ
- шинэ ажлын гэрээ ба ажиллуулах зөвшөөрлийг Хөдөлмөрийн товчоонд үзүүлнэ
- шинэ ажилд орсон өдрөөс эхлэн Хөдөлмөрийн товчоо таныг бүртгэлээс хасаж; эрүүл мэндийн ба нийгмийн даатгалыг төлөх үүрэг ажил олгогчид үүсэн

11

Хөдөлмөрийн товчооны бүртгэлээс хасах

- Хөдөлмөрийн товчоонд бүртгүүлсэн этгээд үүргээ биелүүлээгүй бол Хөдөлмөрийн товчооны бүртгэлээс хасаж болно (дээр дурьдсан нь)
- Хөдөлмөрийн товчоо таныг үүргээ биелүүлээгүй гэж үзвэл үүргээ зөрчилсөн өдрөөс эхлэн бүртгэлээс **эргэж** хасаж болно, үүнд нийгмийн тэтгэлэг мөнгөн тусламж нөлөөлж болно. Бүртгэлээс хасагдсан өдрөөс эхлэн эрүүл мэндийн даатгалыг өөрөө төлөх ёстой.
- Бүртгэлээс хасагдсан өдрөөс хойш 6 сарын дараа, үүргээ бага зэрэг зөрчилвөл 3 сарын дараа, бүртгэлд дахин бүртгүүлж болно.

Хөдөлмөрийн товчооны бүртгэлээс хасах үйл явц:

- 1. захиргааны ажиллагаа үүсгэх** – Хөдөлмөрийн товчоо танд захиргааны ажиллагаа үүсгэх ба шалтгаан, эрх үүргийн тухай мэдээлэх ёстой
- 2. тогтоомжид мэдүүлэг өгөх** – бүртгэлээс хасагдсны шалтгааны тухай бичгээр мэдүүлэг өгч үнэн бодит шинэ байдлыг нотлож болно (жишээлбэл эмчийн магадлагаа)
 - захиргааны ажиллагаа үүсгэснээс хойш ялангуяа 5 хоногийн дотор мэдүүлэг өгч болно
- 3. шийдвэр** – Хөдөлмөрийн товчоо хүсэлт гаргагчийг бүртгэлээс хассан тухай шийдвэрээ бичгээр гаргана, хассан учир шалтгаан ба өдрийг дурьдана
 - энэ шийдвэрийг тогтоосон хугацаанд давж заалдаж болно, давж заалдах өргөдөл гаргахаар шийдвэрийг хойшлуулж болохгүй (анхны тогтоосон, хассан өдөр хүчинтэй байна)
 - Хөдөлмөрийн товчоо таны давж заалдах өргөдлийг татгалзавал энэ бичиг баримтууд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд өгч явуулна (ХНХЯ, ч.х.: MPSV), тэнд хэрэг шалгаж шийдвэр гаргана

12

Ажил хөдөлмөр эрхлээгүй үеийн тэтгэлэг (ажилгүйдлийн тэтгэлэг – ч.х.: Podpora v nezaměstnanosti)

- сүүлчийн 2 жилийн турш доод тал нь 12 сар ажилласан бүртгэлд байгаа хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагч ажил хөдөлмөр эрхлээгүй үед тэтгэлэг (ч.х.: PвN) авах эрхтэй
- ажилгүйдлийн тэтгэлэг авахын тухай зохих өргөдөл гаргаж ажил хийсэн тухай тодорхойлолт ба тэтгэврийн даатгалын бүртгэлийн хуудас хоёрыг үзүүлэх ёстой
- ажилгүйдлийн тэтгэлэг төлөх хугацаа нь хүсэлт гаргагчийн настай холбоотой байна (2012 онд: 50 нас хүртэл хүсэлт гаргагчид 5 сарын турш төлнө, 50 – 55 настай хүсэлт гаргагчид 8 сарын турш төлнө, 55 насаас дээш хүсэлт гаргагчид 11 сарын турш төлнө)
- ажилгүйдлийн тэтгэлгийн хэмжээг ажилтан сүүлчийн ажилд байхдаа авч байсан цалингаас бодож тогтоодог, хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлсэн үед хасаж өөрчлөгдөнө
- та ажлаас халагдсаны тэтгэмж аван халагдсан бол халагдсаны тэтгэмжтэй холбоотой хугацаа өнгөрсний дараа ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй болно. /Анхаар! Та халагдсаны тэтгэмж авах эрхтэй байх нь чухал, тэтгэмж авсан эсэхийг Хөдөлмөрийн товчоо шалгаж хянахгүй! /
- та ажлын харилцааг **ноцтой шалтгаангүйгээр** халагдах бичиг өгснөөр юмуу тохиролцоогоор цуцлавал ажилгүйдлийн тэтгэмж зөвхөн 45 хувийн хэмжээгээр авч болно
- ажилгүйдлийн тэтгэлэг ба үүнийг авах эрхийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлийг Хөдөлмөрийн товчооны ажилтан өгдөг

- ▶ Дэлгэрэнгүй мэдээлэл хүрэх сайт: www.cicpraha.org/infoservis
Танилцуулгын агуулга гарах өдрөөр хүчинтэй байна, магадгүй өөрчлөлтийг татгалзаж болохгүй.
<http://portal.mpsv.cz/sz/>

- ▶ CENTRUM PRO INTEGRACI CIZINCŮ o. s.
Kubelíkova 55, 130 00 Praha 3,
Tel./fax: (+420) 222 713 332, Email: info@cicpraha.org, www.cicpraha.org

Дунд Чех нутгийн ЦИЦ байгууллагийн салбар
Zahradní 46, Kolín, Tel.: 774 866 838, www.cicpraha.org



АЖИЛ АЛДСАН ТОХИОЛДОЛД ЮУ ХИЙХ ВЭ?

2012



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

Энэ танилцуулга гуравдагч орны иргэний интеграцад зориулан Европын сангаас дэмжлэг авсан төсөл юм.

1

Танд ажиллах зөвшөөрөл хэрэггүй тохиолдол

▶ Та байнга оршин суух зөвшөөрөлтэй, олон улсын хамгаалалт эсвэл нэмэлт хамгаалалт олгосон, Чех улсын нутаг дэвсгэрт орогнох эрхтэй буюу байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаад хүнтэй эсвэл Чех улсын/Европын холбооны иргэнтэй хамтран амьдрах зорилгоор суудаг уу?

• **Хөдөлмөрийн намтар (чех хэлээр: životopis – CV)** бичиж бэлтгээрэй ба **санаачлагийн захиар (ч.х.: průvodní/motivační dopis)** бичих тухай мэдэж аваарай. Хөдөлмөрийн намтарт ялангуяа нэр овог, хаяг холвоо, эзэмшсэн боловсрол (сурсан хугацаа, мэргэжил, сургуулийн нэр), хийсэн ажлын дадлага (хугацаа, ажлын байрны нэр, хийсэн ажлын тодорхойлолт ба байгууллагын нэр), хэлний мэдлэг, бусад чадвар мэрэгшил (компютрын мэдлэг, жолооны үнэмлэх) бичээрэй.

• Ажлаа алдсны дараа шууд шинэ ажил олгогчоос ажил олгоогүй бол Хөдөлмөрийн товчоонд (ч.х.: Úřad práce) хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлж болно. Нөхцөлүүд биелүүлвэл эрүүл мэндийн даатгалыг улсаас төлөх ба бүртгэлд байгаа хугацааг (чех хэлээр: „náhradní doba“ гэдэг) тэтгэврийн даатгалд тооцдог. Ажилгүйдлийн үед тэтгэмж авах боломжтой. (доор дурьдсан нь).

• Шинэ ажлын байр эрээрэй. Интернетийн вебсайт, зар мэдээ сонин, өдрийн сонин ба нутгийн сонин ашиглаж болно. Хөдөлмөрийн гэрээ байгуулахад танд ажил хийсэн тухай тодорхойлолт (өмнөх үед „záročkový list“ гэдэг) ба тэтгэврийн даатгалын бүртгэлийн хуудас хэрэгтэй. Та ийм бичиг баримтууд аваагүй бол ажил олгогч хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсны дараа ч таны хүсэлтээр дээрх баримтуудыг гаргах ёстой.

▶ **Анхаар! Хөдөлмөрийн гэрээг ямагт бичгээр байгуулах ёстой (ажлын гэрээ, ажил гүйцэтгэх тухай гэрээ, хөдөлмөрийн үйл ажиллагааны тухай гэрээ) ба та гэрээний нэг хувийг заавал авах ёстой.**

2

Танд Хөдөлмөрийн товчооноос (ÚP) ажиллах зөвшөөрөл (ч.х.: povolení k zaměstnání) хэрэгтэй тохиолдол

▶ Таны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсны дараа ажиллах зөвшөөрөл тань хүчингүй болно. Гэрээ хүчингүй болсноос хойш тодорхой нөхцөлүүд биелүүлвэл танд 60 хоногийн хамгаалах хугацаа байна, тэр үед шинэ ажлын байр олох хэрэгтэй. Хамгаалах хугацааг дор дурдсан тохиолдолд ашиглаж болно:

• таны хөдөлмөрийн харьцаа зохион байгуулах эсвэл эрүүл мэндийн учир шалтгаанаар дуусгавар болсон эсвэл ажил олгогч танд тушаах хугацаа өнгөрсний дараа 15 хоног хүртэл цалин төлөөгүй учраас та хөдөлмөрийн гэрээг даруй цуцласан,

• ба үүний **зэрэгцээ** хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон өдрөөр доод тал нь нэг жилийн хугацаанд, хэрэв энэ хугацаа хөдөлмөрийн харьцаа дуусахаас яг өмнө бол, Чех улсын нутаг дэвсгэрт ажиллах зорилгоор оршин сууж байсан. **Эсвэл** та зэрэгцээгээр хөдөлмөрийн харьцаа дуусгавар болсон өдөр нэг жилээс богино хугацаагаар нутаг дэвсгэрт ажиллах зорилгоор оршин сууж байсан, хэрэв хөдөлмөрийн гэрээ дууссан өдөр нутаг дэвсгэр дээр 3 жил тасралтгүй байсан бол, энэ тохиолдлуудын хувьд (ямар ч зорилгоор) удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй ба/эсвэл удаан хугацааны визтэй Чех улсын нутаг дэвсгэрт суусан.

▶ Хамгаалах хугацаа хөдөлмөрийн харьцаа дуусгавар болсны дараа өдрөөс хойш тооцож эхэлнэ. Энэ хугацааны турш таны хуулиар зөвшөөрсөн оршин суух байдал хүчинтэй байна. Шинэ ажлын байр олход та ба таны шинэ ажил олгогч Хөдөлмөрийн товчоонд шинэ ажиллах зөвшөөрлийн тухай өргөдөл өгөх ёстой.

Ажиллах зөвшөөрлийн тухай өргөдлийг харьяа дүүргийн Хөдөлмөрийн товчоонд (ÚP) өгнө.

▶ **АНХААР! 2012 оны 1-сарын 1-ээс эхлэн Хөдөлмөрийн товчоо тухайн газрын хөдөлмөрийн зах зээлийн байдлаас хамааран гадаадын иргэдэд нарийн мэргэжлийн бус ажлын байрны зөвшөөрөл олгоно. Ажиллах зөвшөөрлийг тухайн ажлын байранд өөр тохиромжтой ажиллах хүч байхгүй бол гадаадын иргэдэд олгоно.**

▶

Ажил олгогч улсын шалгалттай дунд эсвэл дээд сургуулийн боловсролтой хүнийг ажлын байрандаа шаардаж буй тохиолдолд Хөдөлмөрийн товчоо ажлын зөвшөөрөл олгодог. Та ЧУ-д гадаадын гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн нострификацын баталгаа авах хэрэгтэй!

3

Ажил олгогч Хөдөлмөрийн товчоонд мэдэгдэх ёстой

Ажил олгогч гадаад иргэдийг ажиллуулвал Хөдөлмөрийн товчоонд мэдэгдэх үүрэгтэй. Хөдөлмөрийн товчоонд ажил олгогч хөдөлмөрийн харьцаа эхлэх эсвэл дуусгавар болох, ажилд ороогүй мөн тогтоосон ажиллах зөвшөөрлийн хугацаа өнгөрөхөөс өмнө ажлаа дуусгавар болгох, хийж байгаа хөдөлмөр зохион байгуулах эсвэл эрүүл мэндийн шалтгааны улмаас тохиролцохоор эсвэл халагдах өргөдөл өгснөөр дуусгавар болох, хөдөлмөр даруй цуцалснаар дуусгавар болсны тухай 10 хоногийн дотор мэдэгдэнэ; сүүлийн хоёр тохиолдолд дуусгавар болсны учир шалтгаан ч мэдэгдэнэ.

▶

(Анхаар! Танд ажиллах зорилгоор удаан хугацааны оршин суух зөвшөөрөл байгаа хэдий ч хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан тохиолдолд Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар таны оршин суух эрхийг хууль ёсны биш гэж үзэж болно.)

4

ХӨДӨЛМӨРИЙН ТОВЧООНЫ БҮРТГЭЛ (Ч.Х.: EVIDENCE NA ÚŘADU PRÁCE) Хөдөлмөрийн товчоонд хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд хэн бүртгүүлж болох вэ?

• Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй юмуу орогнох эрх эсвэл нэмэлт хамгаалалттай байгаа гадаадын иргэд, Европын холбооны иргэд ба тэдний гэр бүлийн гишүүд хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлж болно. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалыг улсаас төлөх эрхийн тухай мэдээ өгдөг.

• та өөр төрлийн оршин суух зөвшөөрөлтэй байсан ч Хөдөлмөрийн товчоонд хөдөлмөр хийж сонирхогчийн бүртгэлд бүртгүүлж болно (эрүүл мэндийн даатгалыг улсаас төлөх ба ажилгүйдлийн тэтгэлэг олгогдохгүй)

• хэрэв та ажиллаж, өдрийн судалгаа сурч байгаа тохиолдолд мөн жирэмсний амралтын мөнгөн тусламж авдаг эсвэл гуравдугаар зэрэглэлийн тахир дутуу бол хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлж болохгүй. (Тэмдэглэл: Эцэг эхэд олгох тэтгэмж авч байгаа хүн Хөдөлмөрийн товчоонд хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлж болно. Энэ тохиолдолд ажил хайгчийн үүргээ биелүүлэх ёстой.)

• та өндөр насны тэтгэвэр авахад шаардлагатай насанд хүрсэн боловч өндөр насны тэтгэвэр авах эрхгүй байвал хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлж болно, гэхдээ та ажилгүйдлийн тэтгэлэг авах эрхгүй байна

5

Хөдөлмөрийн товчоонд хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд яаж бүртгүүлж болох вэ?

• өөрийн (үнэмлэхэд дурьдсан) байнга оршин суугаа хаягийн харьяаллын дагуу Хөдөлмөрийн товчоонд бүртгүүлнэ

• ажиллах хугацаа дууссаны дараа хэзээ ч бүртгүүлж болно, ажлын 3 хоногийн дотор бүртгүүлвэл ажилгүй болсныг шууд бүртгэж авна

• Хөдөлмөрийн товчоонд 2 хуудас бөглөнө: хөдөлмөр зуучлах тухай өргөдөл (ч.х.: žádost o zprostředkování zaměstnání) ба ажил хөдөлмөр эрхлээгүй үед тэтгэлэг олгох өргөдөл (ч.х.: žádost o podporu v nezaměstnanosti)

6

Бүртгүүлэхэд юу хэрэгтэй вэ?

– хувийн үнэмлэх (оршин суух зөвшөөрлийн үнэмлэх, паспорт)

– ажил хийсэн тухай тодорхойлолт (өмнөх үед „záročkový list“) ба хөдөлмөрийн харьцаа дуусгавар болсон тухай бичиг баримт (халагдах бичиг, тохиролцохын гэрээ, хөдөлмөрийн гэрээ)

– сарын цэвэр дундаж цалингийн тухай тодорхойлолт (ажил олгогч бөглөөд гаргаж өгнө)

– тэтгэврийн даатгалын бүртгэлийн хуудас

• хөдөлмөр сонгохыг хязгаарлах эрүүл мэндийн бэрхшээлтэй байдал эсвэл тахир дутууны зэрэглэлийг харгалзан эмчийн магадлагаагаар шийдвэр гаргаж Хөдөлмөрийн товчоонд үзүүлэх ёстой

• хөдөлмөр эрхлэх тухай хүсэлт гаргагчдын бүртгэлд бүртгүүлсэн тухай бичиг баталгаа аваад 8 хоногийн хугацааны дотор эрүүл мэндийн даатгалын газарт өгөөрэй

7

Хөдөлмөрийн товчоо ямар үйлчилгээнүүд үзүүлдэг вэ?

• хөдөлмөр зуучлах

• ажил хөдөлмөр эрхлээгүй үед тэтгэлэг төлдөг (ч.х.: podpora v nezaměstnanosti)

• бүртгүүлсэн тохиолдолд таны эрүүл мэндийн даатгалыг улсаас төлөх (танд оршин суух зөвшөөрлийн дагуу ийм боломж байвал үүний тухай эрүүл мэндийн даатгалын газраас тодорхой мэдээлэл асууж авч болно)

• Хөдөлмөрийн товчоонд бүртгүүлснээр зарим нийгмийн тэтгэмж тусламж авахад ач холбогдолтой

• Та ажилгүйдлийн болон мэргэшил дээшлүүлэх тэтгэмж авах эрхтэй тохиолдолд Хөдөлмөрийн товчооны ажил хайгчдын бүртгэлд бүртгүүлсэн хугацааг өндөр насны тэтгэвэр ба тахир дутуугийн тэтгэврийг авах эрхийг орлосон хугацаа (даатгал төлөгдөөгүй хугацаа) гэж тооцдог. (урт хугацааны эсвэл олон удаагийн бүртгэлд дээд тал нь 3 жилээр тооцдог)

• хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудад өөрийн хүсэлтээр **мэргэшил дээшлүүлэх сургалт (ч.х.: rekvalifikační kurz)** сонговол курсын зардлыг Хөдөлмөрийн товчоо төлж болно. (Хөдөлмөрийн товчоо курсын үнэд хязгаар тогтооно). Хөдөлмөрийн товчоо хөдөлмөрийн зах зээл дэх тухайн мэргэжлийн эрэлтийг харгалзан үзэж шийдвэр гаргана. Зарим мэргэшүүлэх сургалтанд суухын тулд эмчийн үзлэгт хамрагдах шаардлагатай.

• та мэргэшүүлэх сургалтын саналыг хүлээн авч зөвшөөрсөн бол тухайн курсдээ идэвхтэй оролцох ба төгсгөх үүрэгтэй. (зөвхөн **онцгой шалтгаанаар** мэргэшүүлэх курсыг төгсгөхгүй байж болно, бусад тохиолдолд сургалтын зардлыг та төлөх ёстой)

• Хөдөлмөрийн товчоо ажилд зуучлагч агентуруудын үйлчилгээг ашиглан таныг «тохиролцсон шинэ ажил зуучлах (ч.х.: **sdíleného zprostředkování zaměstnání**)» хөтөлбөрт бүртгүүлж болно. Ажилд зуучлагч агентурууд таныг ажилд зуучилж болно. Ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй бол энэ тэтгэмжийг авна.

8

Таны үүрэг юу вэ?

▶ **Анхаар! Бүртгүүлэхэд хөдөлмөр эрхэлж байгаатай адил төстэй үүрэг үүснэ. Бүртгэлээс хасагдамааргүй байвал Хөдөлмөрийн товчооны зуучлагчтай (ажилтантай) хамтран ажиллаарай:**

• уулзахаар тохиролцсон бол цаг тухайд очоорой

• эрүүл мэндийн шалтгаанаар ирж болохгүй бол урьдчилан мэдэгдэж эмчийн магадлагаа үзүүлнэ

• Хөдөлмөрийн товчоонд санал болгосон ажлаас дэмжих хуудас/ зөвлөлгөөний хуудас (ч.х.: doporučenky) битгий татгалзаарай, зөвлөлгөөний хуудас авбал ажил олгогчтой уулзалт тохиролцож 3 хоногийн хүртэл уулзаарай

• ажил олгогч тантай уулзаж эсвэл үүнийг татгалзаж болно, гэхдээ та ноцтой шалтгаан дурдахгүйгээр ажилд орохыг татгалзаж болохгүй

